


САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Үгэн бус харилцааны аман бус хэлбэрийг аль нь илэрхийлж байна вэ? /1 оноо/
 A. М “Галзуу хулгана” тоглоом дээр суугаад хөдлөхөд түүний царай нь гэнэт дүнсгэр болов
 B. Сурагч О багш нарын баяраар ангийнхаа багшдаа талархлын захидал бичиж бэлгэлжээ
 C. Сурагч Х нь өөрийнхөө санаа бодлыг илэрхийлэхдээ дохионы хэл ашиглажээ
 D. Дохионы хэл нь сонсголгүй хүний тэгш эрхийг хангах суурь үзүүлэлт болдог
2. Буулт хийх гэсэн ойлголтыг аль нь бүрэн илэрхийлж байна вэ? /1 оноо/
 A. Талууд харилцан буулт хийх үйл явц дээр суурилж, харилцан үр ашигтай шийдлийг хэлэлцэн тохиролцох эрмэлзэлтэй байдаг.
 B. Аль аль талдаа үр ашигтай зарчмыг баримтлах байдлаар илэрдэг. Хоёр талын ашиг сонирхлыг дээд зэргээр хангасан хамтын гарцыг олохыг эрмэлздэг.
 C. Зөрчилдөөний гадуур үлдэх, хэлэлцэн зөвшилцөхийг үл ойшоох, эсвэл төвийг сахисан байр суурь барих хандлагатай байдаг.
 D. Бусадтай хамтрах хүсэл сонирхолтой боловч дайчин шаргуу бус зан төлөвөөр илэрдэг. Тодорхой асуудал дээр өөрийн итгэл үнэмшил, байр сууриас ухрах эрмэлзэлтэй байдаг.
3. Дараах харилцааны үйл явцын бүдүүвчийг ажиглаад дутуу хэсгийг нөхөж гүйцээгээрэй. /2 оноо/



- A. a – Дамжуулахыг зорьж буй мэдээллээ үг болон дохио зангаа зэргээр илгээх үйл явц
 b – Илгээгчийн дамжуулж буй мэдээллийг хүлээн авагч тал.
- B. a – Илэрхийлсэн мэдээллийг харилцагч талдаа хүргэх арга хэрэгслүүд
 b – Дамжуулж буй мэдээлэл хүлээн авагч талд хүрч чадсан эсэхийг эргэн нягтлах үйл явц.
- C. a – Ямар нэгэн мэдээлэл дамжуулахыг зорьж буй тал
 b – Илгээгчийн дамжуулж буй мэдээллийг хүлээн авагч тал.
- D. a – Илгээгчээс илгээсэн мэдээллийг хүлээн авч, ойлгох үйл явц.
 b – Дамжуулж буй мэдээлэл хүлээн авагч талд хүрч чадсан эсэхийг эргэн нягтлах үйл явц.

4. Зөрчилдөөний үе шатуудыг тохируулсан жишээтэй нь ажиглаад хэддүгээр мөрний ямар баганад алдаа байгааг тодорхойлоорой. /2 оноо/

Мөр	1-р багана	2-р багана
	Үе шатууд	Жишээ
1	Далд үе	Т-ын найзууд байрны гадаа байдаг сагсны талбай дээр хамт тоглоё бөмбөгөө аваад гараад ир гэхэд, сая манай ах бөмбөг аваад заал руу явсан гэжээ. Харин найзууд нь түүнийг бөмбөгөө харамлаж байна гэж бодов.
2	Хүлээн авах үе	Т өөрийнх нь тухай найзууд нь ямар муухай бодолтой (харамч) явдаг байсныг мэдээд сэтгэл санаа нь тогтворгүй байдалд орж стрессдэж эхэлсэн.
3	Мэдрэх үе	Маргааш нь Т ангидаа ирэхэд найзууд нь түүнтэй дуугарахгүй нэг л сонин хандлагатай байлаа. Хажуудаа суудаг найзаасаа асуутал чамайг өчигдөр бөмбөгөө харамласан гээд уурлаад байсан гэжээ.
4	Оргил үе	Т найзууд дээрээ очиж би бөмбөгөө харамлаагүй, ах аваад явсан байхад яагаад та нар намайг бөмбөгөө харамласан гэж бодож байгаа юм. Та нар намайг өөр юу гэж ер нь боддог уу яг одоо хэлээдэх гэж уурлажээ.
5	Дараах үе	Т-г уурлаж бас бухимдаж байгааг найзууд нь тоосон ч шинжгүй чи угаасаа бөмбөгөө харамласан биз гэжээ. Т найзуудыгаа ямар бодолтой явж байдгийг мэдэж чимээгүй болжээ.

- A. 2-р мөрний 2-р багана буюу жишээг буруу тодорхойлсон
3-р мөрний 2-р багана буюу жишээг буруу тодорхойлсон
B. 3-р мөрний 2-р багана буюу жишээг буруу тодорхойлсон
4-р мөрний 2-р багана буюу жишээг буруу тодорхойлсон
C. 1-р мөрний 1-р багана буюу үе шатыг буруу тодорхойлсон
2-р мөрний 1-р багана буюу үе шатыг буруу тодорхойлсон
D. 1-р мөрний 1-р багана буюу үе шатыг буруу тодорхойлсон
5-р мөрний 2-р багана буюу үе шатыг буруу тодорхойлсон
5. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоорой. /1 оноо/
Хүн төрөлхтний язгуур сэтгэлгээ бөгөөд түүхэн хүмүүс, үйл явдал, газар нутгийн тухай үеэс үед яригдан уламжлагдаж ирсэн аман зохиолын төрлийг гэнэ.
A. Ёс заншил B. Шашин C. Домог D. Зан заншил
6. Нийтийн соёлд аль нь хамаарах вэ? /1 оноо/
A. "Палау де Ла Музыка Каталана" театрт симфони хөгжмийн олон тоглолтуудыг сонсох боломжтой.
B. ROSÉ & Bruno Mars – APT дуу нь "Perfect All-Kill" (PAK) статуст хүржээ. Энэ нь жинхэнэ хит дуу гаргажээ гэсэн үг.
C. Монгол Улсын Үндэсний Урлагийн Их Театрт морин хуур, уртын дууны ардын билиг авьяастнуудын чуулга уулзалт зохион байгуулагджээ.
D. Испанийн алдарт уран барилгачин Антони Гаудигийн бүтээсэн Саграда Фамилиа буюу "Гаудигийн Сүм" нэрээр алдаршсан барилга дэлхийд алдартай.

7. Үндэсний соёлын өвөрмөц төрх байдлыг хадгалан өвлүүлдэг арга зарчмуудын нэг нь тухайн ард түмний ёс заншил мөн. Тиймээс ёс заншлын тухайн алдаатай тодорхойлолтыг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Тухайн ард түмнийхээ төлөвшил, хүмүүжилд онцгой үүрэг гүйцэтгэж байгаагүй.	Нийгмийн амьдралыг зохицуулах арга хэрэгсэл болох ёс суртахууны хэм хэмжээний эх сурвалж болдог.
2-р хэсэг	Ёс заншил нь амьдралын бүх талыг хамардаг. Жишээ нь: эдийн засгийн амьдрал	Нийгмийн амьдралыг зохицуулах гол арга хэрэгсэл болох эрх зүйн хэм хэмжээний эх сурвалж болж чаддаггүй.

- A. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
B. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
D. 2-р хэсэг – А; 1-р хэсэг – Б

8. Соёлын өвийн тухай ойлголтуудын алдаатай тайлбарыг олоорой. /2 оноо/


- Соёлын өв нь үндэсний соёлын нэгдмэл байдлыг бий болгодоггүй.
- Соёлын өв нь дэлхийн соёлын олон янз байдлыг бий болгодог.
- Олон жилийн туршид ихэвчлэн биет өвийг хамгаалахад анхаарч байсан.
- Сүүлийн жилүүдэд биет бус өвд анхаарал хандуулахаа больсон.
- Биет өвийг үндэсний хамгаалалтын жагсаалтад оруулж хамгаалдаг.

- A. 2, 3
B. 1, 3
C. 1, 4
D. 4, 5

9. Мөнгөний үүрэг аль нь вэ? /1 оноо/
- A. Хуваагдмал нэгжтэй
B. Хуримтлалын хэрэгсэл
C. Нийлүүлэлтийг хянах боломжтой
D. Бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн

Дараах графикийг ажиглаад 10-11 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Дараах хөдөлмөрийн зах зээлийн графикийг анхааралтай ажиглаад асуултад хариулаарай.
 $W(\text{wage})$ -цалин (1000 нэгж буюу 1000000 төгрөг)
 $L(\text{Labor})$ -Хөдөлмөрийн тоо хэмжээ



10. Ажиллах хүчний илүүдэл буюу ажилгүйдэл хэд байна вэ? /1 оноо/
- A. 1000
B. 200
C. 100
D. 500

11. Ажиллах хүчний илүүдэл бий болсон цалингийн түвшин, эрэлт, нийлүүлэлтийн хөдөлмөрийн тоо хэмжээг олоорой. /2 оноо/

Цалин	Хөдөлмөрийн нийлүүлэлт буюу ажил хайгчийн тоо хэмжээ	Хөдөлмөрийн эрэлт буюу ажиллах хүчний тоо хэмжээ
.....?	?	?

- A. Цалин-1800; ажил хайгчийн тоо хэмжээ-300; ажиллах хүчний тоо хэмжээ-400
B. Цалин-1800; ажил хайгчийн тоо хэмжээ-400; ажиллах хүчний тоо хэмжээ-300
C. Цалин-3300; ажил хайгчийн тоо хэмжээ-250; ажиллах хүчний тоо хэмжээ-450
D. Цалин-3300; ажил хайгчийн тоо хэмжээ-450; ажиллах хүчний тоо хэмжээ-250
12. Иргэн Б сард 1 сая 600 мянган төгрөгийн цалин авдаг. Захирал нь урамшуулал болгон түүний цалинг 80 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхээр шийдвэр гаргажээ. Гэтэл энэ үед бараа, үйлчилгээний үнийн түвшин 5% өссөн байна. Ийм тохиолдолд бодит цалин хэд болох вэ? /2 оноо/
- A. 1 сая 600 мянган төгрөг
B. 1 сая 660 мянган төгрөг
C. 1 сая 523 мянга 809 төгрөг
D. 1 сая 603 мянга 809 төгрөг
13. Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш зарчмыг дараах агуулгаар тайлбарладаг. Тэгвэл үүнд үл хамаарах ойлголтыг олоорой. /1 оноо/
- A. Ял шийтгэл, хариуцлага үйлдсэн хэрэгт нь тохирсон байх
B. Гэм буруутай нь тогтоогдвол хариуцлагаас үл хэлтрэх
C. Шударгаар шүүлгэх, хуулийг сахих
D. Хууль бүх хүнд адил тэгш үл үйлчлэх
14. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүрэг аль нь вэ? /1 оноо/
- A. Тайван жагсаал, цуглаан хийх
B. Чөлөөт байдлыг хязгаарлах
C. Иргэдийн санаа бодол төлөвшүүлэхэд туслах
D. Төрийн байгууллагын мэдэлд байх
15. Монгол улс нь аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хороо гэсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хуваагддаг тул 4 түвшинтэй байдаг. Энэхүү 4 түвшинг зөв тодорхойлоорой. /2 оноо/
- A. Яам; Аймаг, нийслэлийн захиргаа; Сум, дүүргийн захиргаа; Баг, хорооны захиргаа
B. Нийслэлийн захиргаа; Дүүргийн захиргаа; Аймгийн захиргаа; Сум, багийн захиргаа
C. Ерөнхий сайд; Нийслэл, дүүргийн захиргаа; Аймаг, сумын захиргаа; Хорооны захиргаа
D. Ерөнхийлөгч; Улсын их хурал; Засгийн газар; Шүүх байгууллага
16. Захиргааны байгууллагын нийтлэг шинжүүдэд хамаарах ойлголтуудыг сонгоорой. /2 оноо/

1. Хувь хүний ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхийн төлөө ажилладаг.
2. Хувь хүн, байгууллагын эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргадаг.
3. Иргэдийг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулахаас татгалздаг.
4. Хуульд захирагдаж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

- A. 1, 2
B. 2, 4
C. 1, 3
D. 3, 4

17. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад аль аль эрхүүдийг баталгаажуулсан байдаг вэ? /2 оноо/

1. Соёл, урлагийн бүтээл туурвих, үр шимийг хүртэх
2. Жагсаал цуглаан хийх
3. Нийгмийн халамж хамгааллыг хүртэх эрх
4. Төрийн удирдах хэрэгт оролцох эрх

A. 1, 2 B. 2, 4 C. 3, 4 D. 1, 4

18. Цэгийн онрид тохирох ойлголтыг сонгоорой. /1 оноо/
..... нийгэм дэх төрийн эрх мэдлийн нэг онцлог шинж бол олон түмнээр хүлээн зөвшөөрөгдөж, тэдний дэмжлэгийг авах явдал юм.

A. Авторитар B. Тоталитар C. Ардчилсан бус D. Ардчилсан

19. Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг зөв тодорхойлсон мөрийг олоорой. /1 оноо/

Мөр	Төрийн эрх мэдлийн хуваарилалт	Байгууллага	Нэмэлт тайлбар
1	Хууль тогтоох эрх мэдэл	Улсын Их Хурал	Хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхтэй.
2	Гүйцэтгэх эрх мэдэл	Засгийн газар	УИХ-ын гишүүн, Засгийн газар, Ерөнхийлөгч хууль санаачлах эрх эдэлнэ.
3	Шүүх эрх мэдэл	Шүүх байгууллага	Чуулган нь шүүхийн зохион байгуулалтын үндсэн хэлбэр.

A. Мөр 1, 2-ыг зөв тодорхойлсон байна. C. Мөр 1, 3-ыг зөв тодорхойлсон байна.
B. Мөр 2, 3-ыг зөв тодорхойлсон байна. D. Мөр 3-ыг зөв тодорхойлсон байна.

20. Ардчилсан бус дэглэмийн шинжүүдийг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Гитлерийн үеийн Герман улсын нийгэм	Төрийн хэрэгт иргэд оролцох нь үнэт зүйл нь болж байдаг
2-р хэсэг	Төр засаг нь иргэдийн хүсэл зорилгыг үл харгалзан хэмжээлшгүй эрх эдэлдэг.	Эрх мэдлийг төвлөрүүлэхгүй байхыг гол болгодог

A. 1-р хэсгийн Б; 2-р хэсгийн Б C. 1-р хэсгийн А; 2-р хэсгийн А
B. 1-р хэсгийн А; 1-р хэсгийн Б D. 1-р хэсгийн А; 2-р хэсгийн Б